



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ~~20~~ он ~~05~~ дугаар
сарын ~~07~~ ны өдөр

Дугаар ~~1229~~ /1229


Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанд цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, багшийн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл хийх болсныг үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

2056109

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОЛОН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛ, БАГШИЙН СУРГАЛТЫГ ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Шинэ коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлтээс үүдэн дэлхий нийтэд хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоож, энэхүү цар тахлыг хохирол багатайгаар даван туулахын тулд улс орон бүр нөөц, боломжоо бүрэн дайчилж байгаа энэ үед Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос тодорхой шийдвэрүүдийг хугацаа алдахгүй, шуурхай гарган, үр дүнтэй хэрэгжүүлж, шаардлагатай бүхий л зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна.

Боловсролын үе шат бүхэнд тулгарч байгаа сорилтуудыг эрсдэл багатай даван туулах, ялангуяа 1 дүгээр анги болон төгсөх ангийн оюутан, сурагчдыг бие даан суралцахад нь түлхүү анхаарч ажиллаж байна.

2020 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор дэлхийн 177 улс цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг бүрэн хаасны улмаас 1.27 тэрбум буюу нийт суралцагчдын 72.4 хувь нь хорио, хөдөлгөөний хязгаарлалтад орсон байна.

Монгол Улсын хувьд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан цэцэрлэгийн 263.3 мянган хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн 640.4 мянган суралцагч, их, дээд сургууль, коллежийн 148.4 мянган оюутан хорио, хөдөлгөөний хязгаарлалтад ороод байна.

Боловсролын салбарт танхимын сургалт бүтэн 5 сарын туршид тасалдах нөхцөл байдал үүссэн хэдий ч теле хичээл, цахим сургалтыг цаг алдалгүй зохион байгуулсан нь үр дүнгээ өгч байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас санаачлан 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан "COVID-19 ба боловсрол" сэдэвт дэлхийн Боловсролын сайд нарын цахим хуралд Монгол Улс оролцсон бөгөөд энэхүү хурлаас сайд нарын Ад-хок бүлэг (Ad-hoc Ministerial Group) байгуулагдаж, COVID-19-тэй холбоотойгоор сургууль хаагдсан нөхцөл байдлын талаарх бодлогын асуудлаар мэдээлэл солилцох, боловсролыг тасралтгүй хангахын төлөө хамтран ажиллаж байна.

ЮНЕСКО, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Майкрософт болон Гар утасны холбооны дэлхийн систем (GSMA) зэрэг олон улсын байгууллага, дэлхийн хэмжээний компаниудын COVID-19-ийн тархалтын үед боловсролын салбарт авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаарх мэдээллийг Монгол Улс цаг алдалгүй авч, мөн харилцан мэдээллээ хүргүүлэх байдлаар хамтран ажиллаж байна.

Хичээл, сургалтын үйл ажиллагаагаа зогсоогоод байгаа дэлхийн улс орнуудын боловсролын нэгтгэсэн тайлангаас үзвэл 26 хувь нь теле хичээлээр, 77.3 хувь нь цахим хэлбэрээр, 4.2 хувь нь радио болон бусад хэлбэрээр сургалт зохион байгуулж байгаа бол 39 улс теле болон цахим хичээлийг хослуулан явуулж байгаа юм.

Нэг. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар

Өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон хугацаанд буюу цэцэрлэг, ерөнхий боловсрол, насан туршийн болон тусгай хэрэгцээт боловсролын бүх хичээл, судлагдахуун, элсэлтийн ерөнхий шалгалтад зориулсан нийт 4773 цагийн 82.4 мянган минутын теле хичээлийг 270 гаруй багш зааж, 100 гаруй арга зүйч, судлаачид зөвлөн, давхардсан тоогоор 170 орчим телевизийн ажилтнууд хамтран ажиллаж, монгол, казах, тува болон дохионы хэлээр багш, суралцагч, эцэг эхчүүддээ хүргэж байна.

Теле хичээл маш олон хүний хүч хөдөлмөр, сэтгэл шингэн бүтэж байгаагийн зэрэгцээ багш бүр теле хичээлийг өөрийн арга зүй, сайн туршлагаараа дэмжин, танхимын сургалтад зарцуулдаг цагаас илүү цагийг гаргаж, санаачилгатай ажиллаж байгаа тухай эерэг санал, сэтгэгдлүүд эцэг эх, суралцагчдаас байнга ирж байна.

Теле хичээлийг Монголын Телевизүүдийн холбоотой хамтран дараах чиглэлээр бэлтгэж, 18 телевизээр нэвтрүүлж байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын теле хичээл;
- Ерөнхий боловсролын 1-12 дугаар ангийн судлагдахуун бүрээр теле хичээл;
- Насан туршийн боловсролын теле хичээл;
- Элсэлтийн ерөнхий шалгалтад зориулсан теле хичээл;
- Элсэлтийн ерөнхий шалгалтад зориулсан ЛАЙВ хичээл;
- Эрүүл мэндийн теле хичээл;
- Тусгай хэрэгцээт боловсролын теле хичээл.

Батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын танхимын сургалтын үйл ажиллагааг зогсоосон үеийн судлах бүх агуулгыг теле хичээлд бүрэн шилжүүлсэн бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг 160-165 өдөр танхимаар болон зайнаас хичээл, сургалтын үйл ажиллагаанд бүрэн хамрагдсанд тооцно.

Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газраас теле хичээл, цахим сургалтыг хүүхэд бүрд хүрч байгаа эсэхэд хяналт тавьж, багш нарт зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг удирдан зохион байгуулж байна.

Теле хичээлийг 2020 оны 2, 3 дугаар сард цэцэрлэгийн хүүхдийн 89.1 хувь, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 90 орчим хувь нь үзэж байгаа гэсэн судалгааны дүн гарсан байна.

Теле хичээл, цахим сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад эцэг эх, олон нийтийн оролцоо дэмжлэг туйлын чухал юм. Гэр бүлийн орчинд хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, хөдөөгийн малчдын болон эмзэг бүлгийн хүүхдэд боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэхийн зэрэгцээ гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллын асуудалд онцгойлон анхаарал хандуулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Монголын Телевизүүдийн холбоо болон үүрэн холбооны бүх компаниуд идэвх, зүтгэл гарган хамтран ажиллаж байгаа бөгөөд теле хичээлийг *econtent.edu.mn* цахим хуудсанд байршуулж, хандалт

хийхэд дата унадаггүй байх зохицуулалтыг хийснээр сурагчид цаг хугацаанаас үл хамаарч хичээлээ нөхөн үзэх, давтах, судлах боломжийг бүрдүүллээ.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр теле хичээлийн үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хорио, хөдөлгөөний хязгаарлалтын дараа хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх, хэвийн горимд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

2020-2021 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрт тохиргоо хийж, шинэ хичээлийн жилийн эхэнд бататгах, сэргээн санах, давтах агуулга, арга зүй, аргачлалыг бэлтгэн, багш нарт нэгдсэн заавар, зөвлөмж өгч ажиллахаар төлөвлөж байна.

Хоёр. Дээд боловсролын талаар

2019-2020 оны хичээлийн жилд нийт 95 дээд боловсролын сургалтын байгууллагад 148.4 мянган оюутан, суралцагч бакалавр, магистр, докторын шатлалд суралцаж байна.

Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлүүдээр цахим контент үйлдвэрлэх, оюутныг цахим орчинд суралцахад нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлж байна.

Их, дээд сургууль, коллежийн сургалтын үйл ажиллагааны календарьчилсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан, лекц, семинарын цагт зохицуулалт хийж, цахим хуудсанд байршуулсан хичээлүүдийг татаж үзэх боломжоор хангахын зэрэгцээ даалгавар илгээх хугацааг уян хатан байдлаар зохицуулж байна.

Их, дээд сургууль, коллежийн төгсөх ангийн оюутан бүр диплом бичих шаардлагагүйгээр төгсөлтийн шалгалт өгөх боломжийг олгож, цахим сургалтаар хичээллэх боломжгүй, дараагийн хичээлийн жилд нөхөн судлах хүсэлт гаргасан оюутны хүсэлтийг хүлээн авч, судлан шийдвэрлэж байна.

Түүнчлэн сургалтын төлбөрөө төлөх бололцоогүй байгаа оюутны хичээл сонголт, цахим системд хандах эрхийг нээж, суралцах бүхий л боломжоор хангаж байгаа юм.

Үүрэн холбооны компаниудтай хамтран ажиллаж, төрийн өмчийн их, дээд сургуулийн цахим хуудсанд хандах хандалтыг үнэгүй болгон, хичээл татах, даалгавар илгээхэд дата унахгүй байх зохицуулалтыг хийснээр тодорхой үр дүнгүүд гарч байна.

Гурав. Багшийн мэргэжил дээшлүүлэх зайны сургалтын талаар

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийг дээшлүүлэх хүрээнд улсын төсвөөс жилд дунджаар 2.7 тэрбум төгрөгийг зарцуулж, жилд 7300 орчим багш хамрагддаг. Өөрөөр хэлбэл, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт багш нарын 22.3 хувь нь төвлөрсөн сургалтаар мэргэжлээ дээшлүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр шинэ коронавируст халдварын дэгдэлттэй холбогдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 4751 багш цахим сургалтад хамрагдаж байна.

Багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын уялдаа холбоог сайжруулах, багшийн хөгжих хэрэгцээнд суурилсан нээлттэй, сонголттой, цахим сургалтын хөтөлбөр хөгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн байршил, хэв шинж, хэмжээнд нийцсэн багш бэлтгэх мэргэжлийн хослол, индексийг бий болгох зэрэг асуудал шийдэл хүлээж байгаа нь цар тахал дэгдсэн энэ үед улам тодорхой харагдаж байна.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл сунгахаар шийдвэрлэсэн.

Хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд буюу 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл теле хичээлийг тасралтгүй зохион байгуулж, төлөвлөгдсөн бүх агуулгыг бүрэн олгох юм.

Улсын хэмжээнд ирэх хичээлийн жилд 1 дүгээр ангид элсэн суралцах 81.3 мянган хүүхдийн сургуульд элсэн суралцах бэлтгэлийг хангах зорилгоор эцэг, эхчүүдэд зориулсан гарын авлага, хүүхдэд зориулсан дасгал, даалгаврыг боловсруулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сангийн дэмжлэгээр хэвлүүлж, 5 настай хүүхэдтэй эцэг, эхчүүдэд хүргэх бэлтгэлийг хангаж байна.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, багшийн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээнд одоогийн байдлаар нийт 860 гаруй сая төгрөгийг зарцуулаад байгаа бөгөөд зарим шаардлагатай нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг ЮНЕСКО, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн тусламжтайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Дэлхий нийтийг хамарсан аюулт цар тахлын үед Монгол Улсын нэг ч хүүхэд, оюутны сургалтын үйл ажиллагаа алдагдахгүй, хүртээмжтэй байх зарчмыг баримталж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг 2019-2020 оны хичээлийн жилд 2 дугаар улирлын дүн, зайны сургалтын оролцоо, идэвхийг харгалзан анги дэвшүүлэх, Монгол хэл бичгийн шалгалтыг авахгүй байх зохицуулалт хийх, элсэлтийн ерөнхий шалгалтыг эрсдэлгүй зохион байгуулах, их, дээд сургуулийн төгсөлт, элсэлтийг уян хатан байдлаар хэрэгжүүлэх зэрэг олон талт арга хэмжээг авахаар төлөвлөсөн болно.